*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ МӨНХСАЙХАН ОВОГТОЙ ОДОНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2.2.1. “Хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангах”** | | | | | | | |
| 3. | **Арга хэмжээ 2.3.** Асрахуйн эдийн засагт хөрөнгө оруулах нь өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо-1 | - | 1 | НҮБХХ-тэй хамтран Асрахуйн эдийн засагт хөрөнгө оруулах нь хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт олон талт оролцогчдын төлөөлөл 70 хүн оролцсон. Хэлэлцүүлгийн зорилго нь Монгол Улсад Асрахуйн Эдийн засагтай холбоотой гарч буй ахиц дэвшилд дүн шинжилгээ хийж, эмэгтэйчүүдийн асрах, халамжлах ачааллыг бууруулах, асрахуйн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилготой. Мөн Монгол Улсад хүүхэд харах, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настны асаргаа, халамжийн үйлчилгээг сайжруулах, өргөжүүлэхэд хөрөнгө оруулах төр болон хувийн хэвшлийн уялдаа холбоог хангах, тогтвортой санхүүжилтийн механизмын талаар ярилцахад оршиж байна. Шинэлэг сэдвийн хүрээнд оролцогчид гадны улс орнуудын болон манай улсад хийгдсэн голлох судалгаа, арга хэмжээний талаар санал солилцож, хамтын ажиллагааны эхлэл тавигдсан. Хэлэлцүүлгийн үр дүнд НҮБХХ-тэй хамтран асрахуйн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эдийн засгийг бэхжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр болсон. Энэ ажлын хүрээнд "Монгол Улсад асрахуйн эдийн засгийг бэхжүүлэх нь" төслийн баримт бичигт санал авахааар бодлогын газруудад дотоод албан бичиг хүргүүлж, ирсэн саналыг нэгтгэн тусгаж 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр ТНБД-д танилцуулсан. Мөн төслийн асуудлаар НҮБХХ-ийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй санал солилцох уулзалтуудыг хэд хэдэн удаа хийж салбарын сайдад танилцуулахад бэлэгн болоод байна. | | |
| 4. | **Арга хэмжээ 2.4.** "Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл хамтын ажиллагаа" хэлэлцүүлэг зохион байгуулах | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо-1 | - | 1 | Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр баримталж буй бодлого, иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэж буй үүрэг, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, төр, иргэний нийгмийн байгууллагуудын цаашдын түншлэл, хамтын ажиллагааны зорилго, чиглэлийг тодорхойлох зорилгоор "Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа" хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18 –ны өдөр ГБХНХЯ дээр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон ХЗДХЯ, ЭМЯ, ОУБ, Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл 50 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн үр дүнд цаашид хэд хэдэн тодорхойлсон сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж тулгамдаж буй асуудлуудын гарц шийдлийг эрэлхийлэхэд хамтран ажиллахаар тохиролцов.<br><br>ХНХС-ын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар батлагдсан НҮБ-ын "Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц"-ийн зөвлөмжийн 2024-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулж хэрэгжилтийг 12 сарын 25-ны дотор ирүүлэх тухай албан бичгийг 2025 оны 01 дүгээр сарын 1-ны 03/105 дугаар албан бичгээр холбогдох 18 байгууллагад хүргүүлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр аймгуудын Засаг дарга нарт конвенцийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар чиглэл хүргүүлсэн. Мөн 2025 онд ГБХНХ-ын сайдын аймаг, дүүргийн Засаг дарга нартай байгуулсан “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх гэрээ”-нд орон нутагтаа конвенцийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах талаар тусгасан. Эмэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд болон үүрэг хүлээгч нарыг оролцуулсан хэрэгжилтийн тайланг эрчимжүүлэх уулзалтыг хийхээр төлөвлөж байна. | | |
| 6. | **Арга хэмжээ 2.6.** Үндэсний шилжүүлгийн дансны өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо-1 | - | 1 | Үндэсний шилжүүлгийн дансны хэлэлуүүлэг зохион байгуулахтай холбогдуулан НҮБХАС-ын тэргүүн Халид Шариф болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлгийн үеэр олон улсын зөвлөхүүдээр илтгэл тавиулахаар сэдвүүдийг тохирсон.<br><br>Хэлэлцүүлгийг зохион байгуулах бэлтгэл ажил хангахтай холбогдуулан яам, агентлаг, НББХ зэрэг 10 төрийн байгууллагын оролцоог хангахаар албан бичиг хүргүүлсэн. Орчуулгын төхөөрөмж түрээслэх гэрээ, Хөлсөөр ажиллуулах гэрээний загвар, заал түрээслэх гэрээний загваруудыг бэлтгэж батлуулаад байна.<br><br>Энэхүү өндөр түвшний бодлогын хэлэлцүүлгийн зорилго нь бодлого боловсруулагчид, Засгийн газрын гишүүд, шийдвэр гаргагчид, яамны хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд, эрүүл мэнд, боловсрол, залуучуудын ажил эрхлэлт, эмэгтэйчүүдийн эрх мэдэлжүүлэлтэд оруулах хөрөнгө оруулалтын стратегийн ач холбогдлыг таниулах, хэлэлцэх явдал юм. Хэлэлцүүлэг нь Үндэсний шилжүүлгийн данс (NTA), Үндэсний хугацааны шилжүүлгийн данс (NTTA)-ын олон улсын туршлага дээр тулгуурласан, Монгол Улсын тогтвортой ирээдүйг хангах өсөлтийн чухал салбаруудад чиглэсэн бодит хөрөнгө оруулалтын зөвлөмжүүдийг онцлох юм. | | |
| | **Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН АРГА ХЭМЖЭЭ”** | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** | Гүйцэтгэлий | - | 1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх; | н төлөвлөгөө - 1 Тайлан-2 | | | батлуулсан. Газрын батлагдсан хуваарийн дагуу холбогдох тайлан, мэдээг цаг тухайд нь гаргаж холбогдох газар, нэгжид хүргүүлж байна. | | |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Шийдвэрлэсэн албан бичгийн тоо -20 | - | 15 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна. Хагас жилийн байдлаар 22 албан бичиг албан байгууллагууд руу хүргүүлж, шийдвэрлэж ажилласан байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Монгол улс-Европын Холбооны хүний эрхийн яриа хэлэлцээ”-ний тайланг боловсруулах | | | | 2017 онд байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны Монгол Улс, Европын Холбоо хоорондын хэлэлцээр” –ийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан “Монгол улс-Европын Холбооны хүний эрхийн яриа хэлэлцээ”-нд ялгаварлан гадуурхалт, жендэрийн тэгш байдал, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр, унаач хүүхдийн талаарх мэдээллийг холбогдох газруудын мэргэжилтнүүдээс авч нэгтгэж, боловсруулсан. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай” тогтоолын хэрэгжилтийн тайланг боловсруулах | | | | НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 80 дугаар чуулганаар Монгол Улсаас хоёр жил тутам санаачлан батлуулдаг “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай” тогтоол батлагдахтай холбогдуулан НҮБ-Эмэгтэйчүүд байгууллагаас A/Res/78/181 тогтоолын хэрэгжилтийн илтгэлд “Хөдөөгийн эмэгтэйчүүдийг чадавхжуулах, тэдний хоршоолол, бизнес эрхлэлт, санхүүгийн чадавхийг дэмжихийн тулд хөрөнгө оруулж буй байдал”, “Шийдвэр гаргах үйл явцад хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын бүрэн, тэгш оролцоог хангах тухайд авч хэрэгжүүлж буй ажлууд” сэдвийн хүрээнд холбогдох мэдээллийг бэлтгэж 2025 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр ГХЯ-ны Олон талт хамтын ажиллагааны газарт хүргүүлсэн. | | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.НҮБ-ын Хүн амын сантай хамтран өндөр түвшний бодлогын хэлэлцүүлгүүд зохион байгуулах | | | | НҮБХАС-тай 2025 онд хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Уг төлөвлөлтийн хүрээнд хүн ам зүй, гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжил хамгааллын чиглэлээр салбарын эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагч нарыг оролцуулсан “Think tank“ хэлэлцүүлэг зохион байгуулж бодлогын шийдэл гаргах юм. Энэ хүрээнд:<br>-Төслийн хүрээнд хэрэгжүүлэх Think tank хэлэлцүүлэг зохион байгуулах 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/83 дугаар тушаалыг батлуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -НҮБХАС-ийн мэдээллийг Unip.quantum.plus програм дээр оруулж санхүүжилтийн эрхийг нээлгэсэн.<br><br>-НҮБХАС-ын хэрэгжүүлэгч байгууллагуудын сургалтанд 2025 оны 03 сарын 25-ны өдөр хамрагдсан. Сургалтаар жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэхэд үйл ажиллагаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд, хэрэгжилтийн болон тайлагнах хугацаа, төсөв зэргийг хэрхэн үр дүнтэй тайлагнах талаар мэдээлэл өглөө.<br><br>-03 сарын 12-ны өдөр 2024 оны үлдэгдэл төсөв 11.6 сая төгрөгийн буцаалтыг НҮБХАС данс руу буцааж шилжүүлэх ажлыг зохион байгууллаа. | | |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх тайланг боловсруулах | | | | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооны 143 дугаар хуралдаан Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо 2025 оны 3-р сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид оролцож, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол улсын Засгийн газрын ээлжит долоо дугаар илтгэл, тайланг хэлэлцүүлэв.Тайлантай холбоотой манай яамнаас хүргүүлэх холбогдох заалтуудыг Хөдөлмөрийн бодлогын газар, Салбарын хяналтын газруудаас дотоод албан бичиг хүргүүлэн, авч нэгтгэн ХЗДХЯ-нд 2025 оны 03 сарын 04-ний хүргүүлсэн.<br><br>ХЗДХЯ дээр энэхүү тайлан хамгаалалттай холбоотой ажлын хэсгийн хуралд 03 сарын 05-ний өдөр оролцож мэдээллийг дахин сайжруулж хүргүүлсэн.<br><br>2025 оны 03 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх НҮБ –ын хүний эрхийн хорооны дарга, ажилтнуудын асуусан асуултанд шууд хариулт өгөх viber групп нээж гишүүдийг мэдээллээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангаж, Женевт тайлан хамгаалалтад оролцож буй салбарын төлөөллийг мэдээллээр шуурхай хангах ажлыг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Тайлан хамгаалалттай холбоотой нэмэлтээр тавигдсан асуултуудын хариултуудыг нэгтгэж боловсруулсан. | | |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.Бусад | | | | 1.ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж буй “Алдарт эхийн одонт ээж” хүндэтгэлийн арга хэмжээнд ГБХНХС-ын хэлэх үгийн төслийг 03 дугаар сарын 04-ний өдөр бэлтгэж хүргүүлсэн. Мөн ГБХНХЯ-ны цахим хуудас дээр тавих мэндчилгээний үгийн төсөл боловсруулж яамны хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлсэн.<br>2. ГБДТХуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан шаардлагатай тоо мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан. ХХҮЕГ, МИК, Татварын ерөнхий газар, СҮХ зэрэг байгууллагуудаас судалгаа, мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар авсан.<br>3. Азийн хөгжлийн банкны төсөл боловсруулах загварын дагуу дараах төслүүдийг боловсруулсан. Үүнд:<br>-Гэр бүл төвтэй хөгжлийн цогц үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх төсөл<br>-Оюуны бэрхшээлтэй ахмад настны асрамжийн 300 ортой төвийн барилга угсралтын ажлын төслүүдийг боловсруулж холбогдох хэлтэст хүргүүлсэн.<br>4. Салбарын стратеги төлөвлөгөө боловсруулж батлуулах ажлын хэсэгт гишүүнээр ажилласан.<br>5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө 2022-2031 –ийн хүрээнд жендэрийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгах санал боловсруулж НБТГ-т хүргүүлсэн.<br>6.ГБДТХ-ийн дэд ажлын хэсгийн гишүүнээр ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7.НҮБХАС-ийн Жендэрт суурилсан хүчирхийллийн дэд салбарын “Гамшигийн үе дэх охид эмэгтэйчүүдийг хамгаалах төлөвлөгөө”-ний төсөлд санал өгсөн.<br>8.UPR тайлан боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Удирдлагын академийн Ахлах түшмэлийн багц сургалтанд хамрагдах | Төгссөнг нотлох гэрчилгээ | - | 1 | Удирдлагын академийн Ахлах түшмэлийн багц сургалтанд хамрагдаж амжилттай төгссөн. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Байгууллагаас зохион байгуулж буй хувь хүний хөгжлийн сургалтуудад хамрагдсан байна | Хамрагдсан сургалтын тоо-4 | - | 2 | 1.“Дэлхийн Гэр Бүлийн Өдөр”-ийн хүрээнд “Family College” ТББ –аас 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Хосоороо суралцъя” уриатай “Гэр Бүлийн Өдөр 2025” арга хэмжээнд оролцсон.<br>2. УИХ-ын гишүүн О.Саранчулууны санаачилгаар 5 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулах “Хэрэгжилтэд суурилсан бодлого-Тэгш эрхийн баталгаа” үндэсний хэлэлцүүлгийг бэлтгэл ажлыг хангах, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлгийн хөтөлбөр, төсвийг хэлэлцэж, ажлын хэсгийн түвшинд тохирсон.<br>3.Цагийн менежментийн сургалт, монгол бичгийн сургалтуудад хамрагдсан. | | |
| 3. | **Арга хэмжээ 3.** Хариуцсан ажлын чиглэлээр сургалт, арга хэмжээнд хамрагдаж мэдлэг чадвараа | Хамрагдсан сургалтын тоо-3 | | | 1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас НҮБ-н Хөгжлийн хөгжлийн хөтөлбөр болон НҮБ-н Хүнс хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа Скала төслөөс зохион байгуулж байгаа "Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлсэн байна. | | | | төсөвлөлт" сэдэвт сургалтад 2025 оны 03 сарын 26, 27-ны өдрүүдэд оролцлоо.<br><br>2. 2025 оны 05 сарын 22-23-ны өдрүүдэд Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт” Олон улсын бага хуралд оролцсон. Олон улсын хурлыг жендэрийн эрх тэгш байдал болон уур амьсгалын өөрчлөлтийн холбоо хамаарлын хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулахад чиглэсэн жендэрийн хариуцлагатай бодлого”, “Хөдөөгийн хүн амын аж байдлыг сайжруулах, жендэрийн хариуцлагатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэгийн платформ”, “Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын санхүүжилт”, “Эмэгтэйчүүдээр удирдуулсан уур амьсгалын санаачилга, эмэгтэйчүүдийн манлайллын чадамжийг таниулах нь” сэдэвчилсэн дөрвөн салбар хуралдаанаар олон улсын сайн туршлагыг солилцож, уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх бодитой алхмуудыг хамтран тодорхойллоо. Энэхүү хурлаас уриалга гаргасан. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| Гэр бүлийн бодлогын газрын Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч | М.Одонцэцэг/ ........................ / | 2025.06.03 |
|---|---|---|
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ МӨНХСАЙХАН ОВОГТОЙ ОДОНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтэс

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 2.2.1. “Хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.3.** Асрахуйн эдийн засагт хөрөнгө оруулах нь өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | **Арга хэмжээ 2.4.** “Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл хамтын ажиллагаа” хэлэлцүүлэг зохион байгуулах | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | **Арга хэмжээ 2.6.** Үндэсний шилжүүлгийн дансны өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах | 40 | 7 | 47 | 47 |
| **Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын арга хэмжээ” -ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх; | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | | | | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Монгол улс-Европын Холбооны хүний эрхийн яриа хэлэлцээ”-ний тайланг боловсруулах | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай” тогтоолын хэрэгжилтийн тайланг боловсруулах | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.НҮБ-ын Хүн амын сантай хамтран өндөр түвшний бодлогын хэлэлцүүлгүүд зохион байгуулах | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх тайланг боловсруулах | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.Бусад | 60 | 10 | 70 | 70 |
| **Дундаж оноо:** | | | | 67.7 | 67.7 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Удирдлагын академийн Ахлах түшмэлийн багц сургалтанд хамрагдах | 100% | 15 | 15 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Байгууллагаас зохион байгуулж буй хувь хүний хөгжлийн сургалтуудад хамрагдсан байна | 100% | 15 | 15 |
| 3. | **Арга хэмжээ 3.** Хариуцсан ажлын чиглэлээр сургалт, арга хэмжээнд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | 100% | 15 | 15 |
| **Дундаж оноо** | | | 15 | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | 6 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | 6 |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | 6 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Ажлын цаг ашиглалт | | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 6,4 | 6.4 |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Багаар ажиллах | |
| 3. | Харилцаа | |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 67,7 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 6,4 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо** = ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 97,1 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ГБХАХХ-ийн дарга ............ (албан тушаал) ............ (гарын үсэг) [signature] ... М.Цогтбаатар (албан хаагчийн нэр)

...2025.06.10.... *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Хөгжлийн хошин ............ (албан тушаал) ............ [signature] (гарын үсэг) ... М.Одонцэцэг (албан хаагчийн нэр)

Хөгжлийн бэрхшээлтэй, тогтвортой хэрэглээнд ахлах шинжээч

2025.6.20 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

| | | |
|---|---|---|
| .......................................... | .......................................... | /В.Түвшинтөгөлдөр/ |
| (албан тушаал) | (гарын үсэг) | (албан хаагчийн нэр) |
| | | 2025.06.20 (огноо) |

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

| | | |
|---|---|---|
| .......................................... | .......................................... | /.........................................../ |
| (албан тушаал) | (гарын үсэг) | (албан хаагчийн нэр) |
| | | 2025.06.20 (огноо) |

**Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч**

| | | |
|---|---|---|
| .......................................... | .......................................... | /Л. Мөнхзул/ |
| (албан тушаал) | (гарын үсэг) | (албан хаагчийн нэр) |
| | | 2025.06.20 (огноо) |

АТА12944 9132155 9024070603